

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДҮРЭМ

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Компанийн дүрмийн 10.Б-д заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (“Хороо” гэх)-ны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ” гэх)-ийн ердийн болон хараат бус гишүүн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагыг сонгох, ажиллах боловсруулах журмыг энэхүү дүрмээр зохицуулна.

2. Хорооны гишүүнчлэл

- 2.1. Хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ нь Хорооны гишүүд болон даргыг томилно.
- 2.2. Хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүд байна.

3. Хорооны Нарийн бичгийн дарга

- 3.1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Хорооны Нарийн бичгийн дарга байна.
- 3.2. Хорооны Нарийн бичгийн дарга нь Хороог ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллана.


4. Хорооны хурал

- 4.1. Хороо нь жилд 2 удаа хуралдана. Хурлын хуваарь болон хурлаар хэлэлцэх асуудлыг Хорооноос жил бүр батална.
- 4.2. Хорооны дарга эсвэл хорооны аль нэг гишүүний хүсэлтээр хурлыг зарлан хуралдуулж болно.
- 4.3. Хорооны хуралд Хорооны гишүүдээс бусад этгээд оролцох эрхгүй байна. ТУЗ-ийн дарга (Хорооны гишүүн биш бол), ТУЗ-ийн бусад гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон бусад этгээд Хорооны хуралд урилгаар оролцож болно.
- 4.4. Хорооны хурал нь 2 гишүүний ирцтэйгээр хүчин төгөлдөр болно.
- 4.5. Хорооны Хурлаас гарах бүх шийдвэрийг олонхийн саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Хорооны дарга шийдвэрлэх санал өгнө.

5. Хорооны бүрэн эрх

- 5.1. Хороо нь дор дурьдсан асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах, шийдвэр гаргах бүрэн эрхтэй:

- 5.1.1. Гүйцэтгэх удирдлагын аль нэг гишүүн болон Компанийн ажиллагсдаас Хорооны нарийн бичгийн даргаар дамжуулан мэдээлэл шаардах; Хорооноос гаргасан саналын дагуу Компанийн ажилчдыг удирдан чиглүүлж хамтран ажиллана/



- 5.1.2. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- 5.1.3. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 7.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд жил бүр үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 5.1.4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- 5.1.5. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 5.1.6. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- 5.1.7. ТУЗ-ийн гишүүнээс бусад Компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- 5.1.8. Компанийн тухай хуулийн 59.5-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 (гурван) жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах.

6. Хорооны үүрэг хариуцлага

- 6.1. Хороо нь дараах үүрэгтэй байна:
 - 6.1.1. Хороо нь ТУЗ-д нэр дэвшүүлэх эрх бүхий Компанийн Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлэх тухай санал, нэр дэвшүүлж буй этгээдийн тухай мэдээллийг хүлээн авч тухайн этгээд нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтоосон шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянаад, шалгуур хангахгүй байгаа бол энэ тухай нэр дэвшүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Хараат бус гишүүнд нэрдэвшүүлж байгаа бол хараат бус гэдгийг нотлох мэдээлэл, уг мэдээлэл үнэн зөв болох тухай нэр дэвшигчийн баталгаа зэргийг гаргуулсан байна. Эдгээр мэдээлэлд үндэслэн нэр дэвшигчийг саналын хуудсанд оруулах тухай саналаа ТУЗ-ийн хуралд оруулна.
 - 6.1.2. ТУЗ-ийн гишүүн нас барсан, удаан хугацаагаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ТУЗ-ийн ээлжит хурал хүртэлх хугацаагаар нөхөн сонгох гишүүнийн нэрийг дэвшүүлэх асуудлыг Хороо хариуцан гүйцэтгэнэ.
 - 6.1.3. Хороо нь ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болсон үед ТУЗ-ийн гишүүд үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн тухай ТУЗ-ийн гишүүн тус бүрээр дүгнэлт гаргаж, Хувьэзэмшигчдийн хуралд танилцуулна. Уг танилцуулгад ТУЗ-ийн гишүүн бүр нийт хэдэн удаагийн хуралд оролцохоос хэдэн удаагийн хуралд оролцсон тухай мэдээлэл заавал байх ёстой.
 - 6.1.4. ТУЗ-өөс үүрэг болгосон бусад асуудал.

7. Ажлын тайлан

- 7.1. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь Хорооны хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн бүх гишүүд болон гүйцэтгэх удирдлагад хүргэнэ. Тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн чухал санал, дүгнэлтийг багтаасан байна.

АПУ ХК-ийн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛӨН
30810.1
- 7.1.1. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн хурал, зөвлөгөөн, семинарт оролцсон ирц, идэвх, санаачлага, ТУЗ, харьяалагдах хорооноос өгсөн үүрэг

даалгаврыг хэрхэн биелүүлсэн, ажлаа тайлагнасан байдал зэрэг үзүүлэлтийг харгалзан үнэлэлт, дүгнэлт өгнө.

- 7.1.2. ТУЗ-ийн гишүүн бүрээр ТУЗ-ийн нарийн бичгийн даргын гаргаж өгсөн бүртгэл, хороодын дарга нарын гаргасан тодорхойлолтыг үндэслэн гаргасан дүгнэлтийг тухайн тайлангийн жилийн дараагийн жилийн эхний сарын хуралд танилцуулж байна.
 - 7.1.3. Нэр дэвшүүлэх хороо ТУЗ-ийн гишүүнийг үүрэгт ажлаа тайлант хугацаанд “хангалтгүй гүйцэтгэсэн ” гэж үнэлсэн бол энэ тухай бичгээр гаргасан дүгнэлт, түүнд тухайн гишүүний бичгээр гаргасан тайлбарыг хавсарган ТУЗ-д танилцуулна.
- 7.2. Хороо нь албан үүргийнхээ хүрээнд хийсэн ажлаа жил бүр ТУЗ-д тайлагнана.

АНУ ХК-ийн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛ

ЭХ ХУВЬ